

ДОРНОГОВЬ АЙМГИЙН АНГЛИ ХЭЛНИЙ БАГШ НАРЫН 2-Р ЗӨВЛӨГӨӨН АМЖИЛТТАЙ ЗОХИОН БАЙГУУЛАГДЛАА.



Дорноговь аймгийн “Англи хэлний багш нарын хоёрдугаар зөвлөгөөн”-ийг 2017 оны 4-р сарын 2-ны өдөр АШУҮИС-ийн Дорноговь аймаг дахь салбар Анагаах Ухааны Сургууль дээр зохион байгуулав.

Тус зөвлөгөөнийг зохион байгуулахад салбар сургуулийн “Суурь мэдлэгийн тэнхим”-ийн багш нар, Энх Тайваны Корпусын сайн дурын мэргэжилтэн Мэгги Роджерс нар оролцов. Зөвлөгөөнд Аймгийн Засаг Даргын орлогч Г.Эрдэнэцэцэг, Төрийн захиргаа, удирдлагын хэлтсийн гадаад харилцаа хариуцсан мэргэжилтэн Ж.Түвшинбаяр, Нийгмийн бодлогын хэлтсийн Эрүүл мэнд, спорт, жендер хариуцсан мэргэжилтэн М.Отгончимэг нар хүндэт зочноор уригдан оролцов. Зөвлөгөөний зочин илтгэгч АНУ-ын Элчин сайдын яамны сургалт хариуцсан мэргэжилтэн Т.Алтанцэцэг “Англи хэлний сургалтад тоглоомын аргыг ашиглах нь”, МУБИС-ийн Англи хэлний багш Б.Болормаа “Англи хэлийг сурах болон заахад МООС-г ашиглах нь”, МУИС-ийн Англи хэлний багш Томас Күүк “Хэлний сургалтын хөтөлбөрт идэвхтэй уншлагын аргыг хэрэглэх нь”, Энх Тайваны корпусын сайн дурын мэргэжилтэн Робби Жо Роббин “Хэлц үгийн хэрэглээ”, Сайншанд сумын ЕБ-ын 3-р сургуулийн багш С.Удвал, Замын-Үүд сумын ЕБ-ын 2-р сургуулийн багш Б.Цээпил нарын хамтарсан “Пликерс аппликейшнийг сургалтад ашиглах нь” сэдвүүдээр илтгэл хэлэлцүүлээ. Тус арга хэмжээнд Сайншанд сумын ЕБС-иуд, Дорноговь аймгийн сумдын англи хэлний 18 багш хамрагдан англи хэлний хичээлийг заах арга, багшийн ур чадварын талаар шинэ мэдээ мэдээлэлтэй танилцаж туршлага солилцлоо.